


# НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ХУУЛЬ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС  
ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС  
ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС  
ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР,  
ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

 undeg@ndaatgal.mn

 <http://www.ndaatgal.mn>

 sigomongolia

 Нийгмийн даатгалын ерөнхий газар

 Монгол Улс, 211238, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4-р хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 13/1,  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ  
2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ  
ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНААР  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ  
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ  
ХЭЛЭЛЦЭН БАТАЛСАН.**

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

Та “НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ”-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах КОДЫГ уншуулан авна уу.



## Хуулийн зорилт:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүргийг тодорхойлох харилцааг зохицуулна.



## НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙН ТОО

(2025 оны 04 дүгээр сарын байдлаар)

**АЖИЛ  
ОЛГОГЧ**

**58.1  
МЯНГА**

**АЛБАН  
ЖУРМААР  
ДААТГУУЛАГЧ**

**917.0  
МЯНГА**

**САЙН  
ДУРААР  
ДААТГУУЛАГЧ**

**105.4  
МЯНГА**

Үүнээс малчин  
28.8 мянга

# ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООНД ШИЛЖИНЭ

## ХУВААРИЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Эв санааны зарчимд  
суурилсан тогтолцоо

**1995-2023 он**

## ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНТАЙ УЯЛДУУЛАХ

Хууль, эрх зүйн  
шинэчлэл

**2021-2024 он**

## ХАГАС ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООНД ШИЛЖИХ

Нэрийн дансыг үе  
шаттай мөнгөжүүлж,  
хөрөнгө оруулалт хийх

**2024-2040 он**

## БҮРЭН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ

Бүрэн хуримтлалын  
тогтолцоог нэвтрүүлэх  
эхний үе шат

**2041-хойш**



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨРӨЛ

- 1 Тэтгэврийн даатгал
- 2 Тэтгэмжийн даатгал
- 3 Ажилгүйдлийн даатгал
- 4 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал
- 5 Эрүүл мэндийн даатгал



### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨРӨЛ ТУС БҮР БИЕ ДААСАН САНТАЙ БАЙХ БӨГӨӨД САНГИЙН ОРЛОГО ДАРААХ ЭХ ҮҮСВЭРЭЭС БҮРДЭНЭ:

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Төрөөс төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны орлого
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгууль
- Улсын төсвөөс олгох хөрөнгө
- Хуульд заасан бусад эх үүсвэр

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛБЭР



АЛБАН ЖУРМААР



САЙН ДУРААР

## АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨРӨЛ	АЖИЛ ОЛГОГЧИЙН ТӨЛӨХ (%)	ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ (%)
ТЭТГЭВЭР	8.5	8.5
ТЭТГЭМЖ	1.0	0.8
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН	0.5, 1.5, 2.5	-
АЖИЛГҮЙДЭЛ	0.5	0.2
ЭРҮҮЛ МЭНД	2.0	2.0
<b>ШИМТГЭЛИЙН ДҮН</b>	<b>12.5, 13.5, 14.5</b>	<b>11.5</b>

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг даатгуулагчийн **ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар** ялгаатай төлнө.



ОФФИСЫН  
АЖИЛТАН

**0.5%**



БАГШ

**0.5%**



БАРИЛГЫН  
МУЖААН

**1.5%**



СТАНЦЫН  
ЗУУХНЫ  
МАШИНИСТ

**2.5%**

**ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ НАСАНД ХҮРСЭН  
АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА ТЭТГЭВЭР  
АВАГЧ ӨӨРӨӨ ХҮСВЭЛ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД  
ДААТГУУЛАХГҮЙ БАЙЖ БОЛНО.**

**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД  
ДААТГУУЛАХ БОЛ**

**19.3-21.3%**

**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД  
ДААТГУУЛАХГҮЙ БОЛ**

**2.3-4.3%**

?



**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ**

**17%**

**ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ**

**1.8%**

**ҮОМШӨ-ний даатгал**

**0.5-2.5%**

**ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ**

**1.8%**

**ҮОМШӨ-ний даатгал**

**0.5-2.5%**

**ТЭТГЭВЭР АВАГЧ ӨӨРӨӨ СОНГОНО**

## САЙН ДУРЫН ДААТГАЛ

### НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ХЭН ДААТГУУЛАХ ВЭ?

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Малчин, туслах малчин
- Оюутан суралцагч
- Хөдөлмөрийн чадвараа алдсан хүн
- Нэг ба түүнээс дээш сарын хугацаагаар захиргааны цалингүй чөлөө авсан ажилтан
- Гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх (эцэг)
- Төрөөс олгох урамшуулалд хамрагдсан иргэн
- Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн
- Монгол Улсад амьдарч байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн



### САЙН ДУРЫН ДААТГАЛД ШИНЭЭ ДААТГУУЛАХДАА



Гэрээний хугацаа, шимтгэл төлөх сарын цалин хөлс, орлого, шимтгэл төлөх нийгмийн даатгалын байгууллага, ажил эрхлэлтийн байдал зэрэг гэрээний нөхцөлөө даатгуулагч өөрөө тодорхойлно.

## САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ
Тэтгэврийн даатгалд	11.5
Тэтгэмжийн даатгалд	1.0
ҮОМШӨ даатгалд	1.0
Нийт	13.5

Даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, түүнийг 7 дахин нэмэгдүүлсэнээс ихгүй хэмжээгээр цалин хөлс, орлогоо өөрөө тодорхойлж, **13.5%** хувиар шимтгэлээ төлнө



Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох бүрд өөрчлөгдөх болно.

## ШИМТГЭЛ ТӨЛӨХ ХЭМЖЭЭ

Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	Сарын төлөх шимтгэлийн дүн
792,000	106,920
1,000,000	135,000
1,500,000	202,500
2,000,000	270,000
2,500,000	337,000
3,000,000	405,000
4,000,000	540,000
5,000,000	675,000
5,544,000	748,440




## САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭГ ХЭРХЭН БАЙГУУЛАХ ВЭ?

- Аймаг, дүүргийн **нийгмийн даатгалын байгууллагад** хандаж болно.
- “Нийгмийн даатгал” **гар утасны аппликейшн** ашиглах боломжтой.
- **ndaatgal.mn** хуудасны Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авах хэсэгт хандах боломжтой.



## ТЭТГЭВРИЙН БОЛОН ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТӨРӨӨС ХАРИУЦАН ТӨЛӨХ ЗОХИЦУУЛАЛТ;



Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн **50 хувийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон** тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлнө.

### 3 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДЭЭ АСАРЧ БАЙГАА ЭХИЙН САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

ӨӨРӨӨ МЭДҮҮЛСЭН ЦАЛИН ХӨЛС ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ОРЛОГО	САРД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ДҮН	ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН, УЛСЫН ТӨСВӨӨС ТӨЛӨХ ДҮН	ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ДҮН
▼ 792,000	106,920	49,500	54,420
1,000,000	135,000	49,500	85,500
1,500,000	202,500	49,500	153,000
2,000,000	270,000	49,500	220,500
2,500,000	337,500	49,500	288,000
3,000,000	405,000	49,500	355,500
4,000,000	540,000	49,500	490,500
5,000,000	675,000	49,500	625,500
▲ 5,544,000	748,440	49,500	698,940

## ЦАЛИН ХӨЛСӨНД ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮРИЙГ ЖИЛ БҮР ШИНЭЧЛЭН ТОГТООНО



жил бүрийн  
**08 ДУГААР САРЫН 01**  
ТОГТООНО




дараа жилийн  
**01 ДҮГЭЭР САРЫН 01**  
МӨРДӨНӨ

### ШИМТГЭЛ ТӨЛӨХ ОРЛОГЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ЯЛГААТАЙ ТОГТООСОН

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн шимтгэл ногдуулан төлөх сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.




Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй, нийгмийн даатгалын байгууллагатай сайн дураар даатгуулах гэрээ байгуулсан эх эсхүл эцгийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон улсын төсвөөс сар бүр төлнө.**



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭЭ АСАРЧ БАЙГАА ЭХ, ЭЦГИЙН САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ**

ӨӨРӨӨ МЭДҮҮЛСЭН ЦАЛИН ХӨЛС ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	САРД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ДҮН	УЛСЫН ТӨСВӨӨС ТӨЛӨХ ДҮН	ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ДҮН
▼ 792,000	106,920	91,080	15,840
1,000,000	135,000	91,080	43,920
1,500,000	202,500	91,080	111,420
2,000,000	270,000	91,080	178,920
2,500,000	337,500	91,080	246,420
3,000,000	405,000	91,080	313,920
4,000,000	540,000	91,080	448,920
5,000,000	675,000	91,080	583,920
▲ 5,544,000	748,440	91,080	657,360

Малчин, туслах малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн **50 хувийг** улсын төсвөөс хариуцан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөх ба улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна.



### МАЛЧИН, ТУСЛАХ МАЛЧНЫ САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

ӨӨРӨӨ МЭДҮҮЛСЭН ЦАЛИН ХӨЛС ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	САРД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ДҮН	УЛСЫН ТӨСВӨӨС ТӨЛӨХ ДҮН	ДААТГУУ-ЛАГЧИЙН ТӨЛӨХ ДҮН
▼ 792,000	106,920	45,540	61,380
1,000,000	135,000	45,540	89,460
1,500,000	202,500	45,540	156,960
2,000,000	270,000	45,540	224,460
2,500,000	337,500	45,540	291,960
3,000,000	405,000	45,540	359,460
4,000,000	540,000	45,540	494,460
5,000,000	675,000	45,540	629,460
▲ 5,544,000	748,440	45,540	702,900



## МАЛЧИН ДААТГУУЛАГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН 50 ХУВИЙГ УЛСЫН ТӨСВӨӨС ХАРИУЦАН ТӨЛНӨ



### МАЛЧИН ДААТГУУЛАГЧ

Тэтгэврийн даатгал **11.5%**

Тэтгэмжийн даатгал **1%**

Үйлдвэрийн осол, мэргэжлийн шалтгаалсан өвчний даатгал **1%**

**Нийт 13.5 % буюу  
792.000₮x13.5%=106.920₮**

Зөвхөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 11.5%-ийн 50%-ийг Улсын төсвөөс хариуцан 5 жилээс ихгүй хугацаанд төлнө.

**792.000₮x11.5%/2=45.540₮**

Малчин даатгуулагч өөрөө төлөх шимтгэл

**106.920₮-45.540₮=61.380₮**

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Та “Тэтгэврийн даатгал”-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах КОДЫГ уншуулан авна уу.



## Хуулийн зорилт:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу тэтгэврийн даатгалд даатгуулж шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.




## ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ТОО

(2025 оны 04 дүгээр сарын байдлаар)

**511.7**  
**МЯНГА**

## ДУНДАЖ ТЭТГЭВЭР



# ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ

## ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САНД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

(Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос)

Даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ
Ажил олгогч	8.5
Албан журмын даатгуулагч	8.5
Сайн дурын даатгуулагч	11.5



## ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭРТ ӨӨРИЙН СОНГОЛТООР ГАРНА

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2025 оны тухайд **22 жил ба түүнээс дээш** хугацаанд төлсөн **60** насанд хүрсэн эрэгтэй, **55** насанд хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ **10-20 хүртэл жил** төлсөн, төрсөн ондоо **харгалзах насанд** хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан **4 ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл өсгөсөн ээж** 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол **50** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

**Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс малчнаар 15-аас доошгүй жил** ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй **55** насандаа, **12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй 50** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс **газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд 10-аас доошгүй жил** ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй **50** насандаа, 7 жил 6 сараас доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй **45** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс **хөдөлмөрийн хүнд нөхцөлд 12 жил 6 сараас доошгүй жил** ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй **55** насандаа, 10-аас доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй **50** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.



**ЭРЭГТЭЙ 60, ЭМЭГТЭЙ 55 НАСАНД ХҮРЭЭД  
ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ЭРХТЭЙ**

Тэтгэвэр тогтоолгох он	Шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа
<b>2025</b>	<b>22 жил</b>
2026	22 жил 3 сар
2027	22 жил 6 сар
2028	22 жил 9 сар
2029	23 жил
2030	23 жил 3 сар
2031	23 жил 6 сар
2032	23 жил 9 сар
2033	24 жил
2034	24 жил 3 сар
2035	24 жил 6 сар
2036	24 жил 9 сар
2037	25 жил

**ДААТГУУЛАГЧ ШИМТГЭЛ ТӨЛСӨН БАЙВАЛ ЗОХИХ ДООД  
ХУГАЦААГ ХАНГААГҮЙ БОЛ ТӨРСӨН ОНДОО ХАРГАЛЗАХ  
НАСАНД ХҮРЭЭД ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ЭРХТЭЙ**

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас	Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас
1964	61 нас 9 сар	1969	56 нас 9 сар
1965	62 нас	1970	57 нас
1966	62 нас 3 сар	1971	57 нас 3 сар
1967	62 нас 6 сар	1972	57 нас 6 сар
1968	62 нас 9 сар	1973	57 нас 9 сар
1969	63 нас	1974	58 нас
1970	63 нас 3 сар	1975	58 нас 3 сар
Жил бүр 3 сараар нэмэгдэн 1977 онд ба түүнээс хойш төрсөн бол 65 настай тэтгэвэр тогтоолгоно.		Жил бүр 3 сараар нэмэгдэн 2002 онд ба түүнээс хойш төрсөн бол 65 настай тэтгэвэр тогтоолгоно.	

## ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙГ НАС ХАРГАЛЗАХГҮЙГЭЭР ТОГТООДОГ ОНЦЛОГ ТОХИОЛДОЛ

Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад **нийтдээ 20-оос доошгүй жил** доорх ажил мэргэжлээр ажилласан, эсхүл **нийтдээ 25 жил**, үүнээс тухайн мэргэжлээр **15-аас доошгүй жил** ажиллаж шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгож болно.



Гоцлол дуучин, гоцлол бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчин;

Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд **25-аас доошгүй жил** ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч;



## ТЭТГЭВЭР БОДОХ АРГА СОНГОЛТОЙ БОЛОО

**1960.01.01-ний  
өдрөөс өмнө  
ТӨРСӨН БОЛ**



### **ЦАЛИНД ҮНДЭСЛЭСЭН**

аргаар (даатгуулагчийн дараалсан 5 жилийн дундаж цалин хөлснөөс шимтгэл төлж ажилласан жилд үндэслэн тооцно



**1979.01.01-ний өдөр  
ба түүнээс хойш  
ТӨРСӨН БОЛ**



### **НЭРИЙН ДАНСНЫ**

аргаар (даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээнд үндэслэн тооцно)

**1960.01.01-ний өдрөөс 1979.01.01-ний  
өдөр хүртэлх хугацаанд  
ТӨРСӨН БОЛ**



**АЛЬ НЭГ АРГЫГ ӨӨРӨӨ СОНГОНО**

## ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх)
- Хэрэв хөдөлмөрийн дэвтрээ үрэгдүүлсэн бол архивын лавлагаа, эсхүл ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэр
- Ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэр
- 1995 оноос өмнөх хугацааны цалингаар тэтгэврээ тогтоолгох бол дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт
- Цэрэгт алба хаасан бол цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа



## 20% ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ТУСГАЙ ЗОХИЦУУЛАЛТ

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч гэр бүлийн аль нэг нь нас барсан тохиолдолд түүний авч байсан тэтгэврээс **20 хувиар** тооцсон дүнгээр нөхөр эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

✔ **ГЭР БҮЛ БОЛСНОО  
БҮРТГҮҮЛЖ, БАТЛУУЛСАН**

✔ **20 БА ТҮҮНЭЭС  
ДЭЭШ ЖИЛ ХАМТ АМЬДАРСАН**

## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР АВАХ ЭРХ

Даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа **50 ба түүнээс дээш** хувиар байнга буюу удаан хугацаагаар алдсан тохиолдолд түүний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааран хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоодог.



#### Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 ба түүнээс дээш жил төлсөн бол
- Эсхүл хөдөлмөрийн чадвараа алдахын өмнөх сүүлийн 5 жилд нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн бол

#### Хөдөлмөрийн чадвар алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэвэр:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн чадвараа алдахаас өмнө нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн бол

**Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар  
алдалтын хувь, хугацааг ЭРҮҮЛ МЭНДИЙН  
МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛ тогтооно.**

## ДААТГУУЛАГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫГ

- 70 ба түүнээс дээш хувиар тогтоосон тохиолдолд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсанд
- 70 хүртэл хувиар тогтоосон тохиолдолд хөдөлмөрийн чадвараа хагас (хэсэгчлэн) алдсанд тус тус тооцно

## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР БОДОХ АРГАЧЛАЛ

### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ БҮРЭН ТЭТГЭВРИЙГ ТООЦОХДОО

- ✓ Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэвэр бодох аргачлалаар буюу **сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогын 45 хувиар тогтоож, 20-иос илүү ажилласан жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар** бодож нэмэгдэл олгоно.
- ✓ Даатгуулагч нь хөдөлмөрийн чадвараа хагас алдсан тохиолдолд тэтгэврийг дээр дурдсан хэмжээнээс **хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээгээр** бодож тогтооно.




### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН ТЭТГЭВРИЙГ ТООЦОХДОО

- ✓ Өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр бодох аргачлалаар тооцсон тэтгэврийн хэмжээнээс **хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн хувьд 100 хувиар, хагас алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр** тус тус бодож тогтооно.

## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх)
- Хэрэв хөдөлмөрийн дэвтрээ үрэгдүүлсэн бол архивын лавлагаа, эсхүл ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэр
- Ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэр
- 1995 оноос өмнөх хугацааны цалингаар тэтгэврээ тогтоолгох бол дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт
- Цэрэгт алба хаасан бол цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадласан шийдвэрийн хуудас
- Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол тогтоосон акт



## ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР



Нас барсан тэжээгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааран түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоодог.



### Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг **20-иос доошгүй жил** төлсөн бол
- Эсхүл нас барахын өмнөх 5 жилд **нийтдээ 36 ба түүнээс дээш сар** шимтгэл төлсөн бол

### Тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэвэр:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг **нийтдээ 60-аас доошгүй сар**, үүнээс **12 сар нь тасралтгүй төлсөн** даатгуулагч нас барсан бол

## ТЭЖЭЭГЧИЙН ГЭР БҮЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРГҮЙ ГИШҮҮД

**1**

Төрсөн, дагавар, үрчлэн авсан **19 нас хүрээгүй хүүхэд** (үүнд эцгээ нас барснаас хойш төрсөн хүүхэд хамаарна)

**2**

Тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон **төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд**

**3**

Тэжээгчийг нас барахын өмнө тэтгэврийн насанд хүрсэн, эсхүл хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон **эхнэр, нөхөр, тэжээн тэтгэх өөр хүнгүй эцэг, эх**

**4**

Тэжээгчийн хууль ёсоор асран хамгаалж, харгалзан дэмжиж байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон **ач, зээ**

## ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР БОДОХ АРГАЧЛАЛ

- ✓ Тэжээгчээ алдсаны тэтгэврийг өндөр насны тэтгэвэр бодох аргачлалаар буюу сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогын 45 хувиар тогтоож, 20-иос илүү ажилласан жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож нэмэгдэл тооцсон хэсгээс хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан дор дурдсан хувь хэмжээгээр бодно.

Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо	Тэтгэвэр бодох хувь
3 ба түүнээс дээш	100%
2	75%
1	50%

- ✓ Тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэврийг өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр бодох аргачлалаар тооцсон тэтгэврийн хэмжээнээс гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан 50 хувь, 75 хувь, 100 хувиар тус тус бодох тогтооно.



## ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх)
- 1995 оноос өмнөх хугацааны цалингаар тэтгэврээ тогтоолгох бол дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт
- Тэжээгч цэрэгт алба хаасан бол цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа
- Асран хамгаалагчаар тогтоосон тухай харьяа аймаг, сум, дүүргийн Засаг даргын захирамж
- Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд хуваан олгох тохиолдолд холбогдох хүсэлт, шүүхийн шийдвэр



# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Та “Тэтгэмжийн даатгал”-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах КОДЫГ уншуулан авна уу.



## Хуулийн зорилт:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалд шимтгэл төлж даатгуулсан даатгуулагчид тэтгэмж олгох, тэтгэмжийн хэмжээ, хугацаа, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.



## ТЭТГЭМЖ АВСАН ДААТГУУЛАГЧИЙН ТОО

(2025 оны эхний 04 дүгээр сарын байдлаар)

**32.2**  
**МЯНГАН**  
**ХҮН**

ХӨДӨЛМӨРИЙН  
ЧАДВАР ТҮР  
АЛДСАНЫ  
ТЭТГЭМЖ

**17.4**  
**МЯНГАН**  
**ХҮН**

ЖИРЭМСНИЙ  
БОЛОН  
АМАРЖСАНЫ  
ТЭТГЭМЖ

**9.9**  
**МЯНГАН**  
**ХҮН**

АЖИЛГҮЙДЛИЙН  
ТЭТГЭМЖ

**4.5**  
**МЯНГАН**  
**ХҮН**

НАС БАРСАН  
ДААТГУУЛАГЧИЙН  
ГЭР БҮЛИЙН  
ГИШҮҮНД ОЛГОХ  
ТЭТГЭМЖ

## ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ

### ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС

Даатгуулагчийн төрөл	Төлөх шимтгэлийн хэмжээ (хувиар)
Ажил олгогч	1.0
Албан журмын даатгуулагч	0.8
Сайн дурын даатгуулагч	1.0

### ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС ДААТГУУЛАГЧИД ОЛГОХ ТЭТГЭМЖ НЬ ДОР ДУРДСАН 3 ТӨРӨЛТЭЙ БАЙНА.

1

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

2

ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ

3

НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ

## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

- ✓ Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө тэтгэмжийн даатгалын шимтгэлийг дараалсан 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.
- ✓ Мөн даатгуулагч эх хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу эрүүл мэндийн шалтгаанаар үр хөндүүлсэн бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.



## ТЭТГЭМЖ БОДОХ ХУВЬ, ХЭМЖЭЭ НЭМЭГДСЭН

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааралтайгаар сүүлийн дараалсан 3 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дор дурдсан хувь хэмжээгээр бодно.

Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа (сараар)	Тэтгэмж бодох хэмжээ (хувиар)
3-59	50
60-119	55
120-179	60
180 ба түүнээс дээш	75

Ердийн өвчин, ахуйн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөний улмаас эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас ажлын 10 өдрийн дотор цахимаар эсхүл цаасан хэлбэрээр бичиж олгоно

## ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 12 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс жирэмсний амралт авахын өмнөх сүүлийн 6 сард тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.



### ИХЭР ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН БОЛ ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭНЭ



Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 4 сар (эх ихэр хүүхэд төрүүлсэн бол 4 сар 20 хоног)-ын хугацаанд **сүүлийн 12 сарын цалин хөлс, орлогын дунджаас 100 хувиар** тооцож олгоно.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд **нийтээр тэмдэглэх баярын өдөр** тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг **нэмэгдүүлэн олгоно.**

## НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ



Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаанд төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.

Мөн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байсан иргэн нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.

### ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ:

- ✓ Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж **2.000.000** (хоёр сая) төгрөг байна.
- ✓ Нас барсан даатгуулагч амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн бол **3.500.000** (гурван сая таван зуун мянган) төгрөг байна.

## АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛ

### АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС

Даатгуулагчийн төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ
Ажил олгогч	0.5
Даатгуулагч	0.2

### АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС



#### Даатгуулагчид:

Ажилгүйдлийн тэтгэмж олгоно.



#### Ажил олгогчид:

Шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.



### АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВАХ ЭРХ

- Даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 24 сараас доошгүй хугацаагаар, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ.
- Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.

## АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ

✓ Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан **9 сарын цалин хөлс**, түүнтэй адилтгах орлогын дунджаас тооцож, даатгуулагчийг ажлаас чөлөөлөгдсөн өдрийн дараагийн өдрөөс эхлэн ажлын **76 өдрийн хугацаанд** дараах хувь хэмжээгээр олгоно.

Ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа (сараар)	Тэтгэмж бодох хэмжээ (хувиар)
24-59	<b>50</b>
60-119	<b>55</b>
120-179	<b>60</b>
180 ба түүнээс дээш	<b>70</b>

Ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг **ажлын өдөртэй адилтган тооцож**, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгоно;

### АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ОЛГОЛТЫГ ЗОГСООХ ҮНДЭСЛЭЛ

Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж албан журмаар шимтгэл төлж эхэлсэн

Өндөр насны эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон


Үндэслэлгүйгээр ажилгүйдлийн тэтгэмж авч байсан нь тогтоогдвол

Цэргийн жинхэнэ албыг биеэр хаахаар татагдсан

Хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон

Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа нас барсан

## АЖИЛ ОЛГОГЧИД ҮЗҮҮЛЭХ ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ



Дараах нөхцөлийг хангасан  
Ажил олгогчид ажилгүйдлийн  
даатгалын шимтгэлийн  
хөнгөлөлт үзүүлнэ.

- ✓ Даатгуулагчийг тогтвор суурьшилтай ажиллуулсан
- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн ажилгүйдлийн даатгалын сангаас **3 жил дараалан** ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй

### ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ

Ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож, **3 жил** тутамд нэг удаа шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.

## ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ ХУГАЦАА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Хөдөл-  
мөрийн  
чадвар түр  
алдсаны  
тэтгэмж

Эмнэлгийн хуудас  
авсанаас хойш 4  
долоо хоногийн  
дотор, хүндэтгэн үзэх  
шалтгаантай бол 6  
сарын дотор

- Эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас (цаасан болон цахим хэлбэрээр)
- Тэтгэмж авах өргөдөл (цаасан болон цахим хэлбэрээр)

Жирэмсний  
болон  
амаржсаны  
тэтгэмж

Эмнэлгийн хуудас  
авсанаас хойш 4  
долоо хоногийн  
дотор, хүндэтгэн  
үзэх шалтгаантай  
бол 6 сарын дотор

- Эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас (цаасан болон цахим хэлбэрээр)
- Тэтгэмж авах өргөдөл (цаасан болон цахим хэлбэрээр)

Нас барсан  
даатгуулаг-  
чийн гэр  
бүлийн  
гишүүнд  
олгох  
тэтгэмж

Даатгуулагчийг  
нас барснаас хойш  
6 долоо хоногийн  
дотор, хүндэтгэх  
шалтгаантай бол  
6 сарын дотор

- Нас барсны гэрчилгээний хуулбар
- Гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхийн хуулбар
- Амьгүй донор болсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт
- Тэтгэмж авах өргөдөл

Ажилгүйд-  
лийн  
тэтгэмж

Ажлаас чөлөөлсөн  
тухай ажил олгогчийн  
шийдвэр гарсан  
өдрөөс хойш 4 долоо  
хоногийн дотор,  
хүндэтгэх шалтгаантай  
бол 3 сарын дотор

- Ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр
- Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт
- Тэтгэмж авах өргөдөл (цаасан болон цахим хэлбэрээр)

## **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

Та “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр”-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах КОДЫГ уншуулан авна уу.



### **Хуулийн зорилт:**

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоох, олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.



## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС

(2025 оны эхний 04 дүгээр сарын байдлаар)

**4,7**  
**МЯНГАН**  
**ХҮН**



**16,3**  
**ТЭРБУМ**  
**ТӨГРӨГ**

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛ

ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС

**Ажил олгогч ажлын байрны хөдөлмөрийн  
нөхцөлөөс хамааран ялгаатай төлнө.**

Даатгуулагчийн төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ
Ажил олгогч	0.5, 1.5, 2.5
Сайн дурын даатгуулагч	1.0

## ДАРААХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨР ОЛГОЖ, ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ ҮЗҮҮЛНЭ.

### ТЭТГЭВЭР

- Хөдөлмөрийн чадвар алдсаны
- Тэжээгчээ алдсаны

### ТЭТГЭМЖ

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох

### ТӨЛБӨР

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын
- Даатгуулагчийн эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын

### ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

- Ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт

## ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР



- ✔ Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчны улмаас хөдөлмөрийн чадвараа **30 ба түүнээс дээш хувиар** алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- ✔ Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг даатгуулагчийн **сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос** хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар тогтооно.

### ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР



- ✔ Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчны улмаас нас барсан бол **түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн** тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- ✔ Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн **сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос** дараах хувь хэмжээгээр тогтооно.

Хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо	Тэтгэвэр бодох хэмжээ
3 ба түүнээс дээш	<b>100</b>
2	<b>75</b>
1	<b>50</b>

### ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВРИЙГ

- Хүүхдэд 19 нас хүртэл нь
- Хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл хугацаанд олгоно.

## ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа **түр алдсан** даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан түүний **сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 100 хувиар тооцно.**



## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖИЙГ

- Хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн дараалсан 12 сарын дотор **180 хоног хүртэл;**
- Эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны **тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл** хугацаанд олгоно.

### НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ

Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ **2.000.000** төгрөг бөгөөд хэрэв нас барсан даатгуулагч амьгүй донор болж эс, эд эрхтнээ бусдад шилжүүлсэн бол **3.500.000** төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.

## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ТӨЛБӨР

- ✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний (ҮОМШӨ) улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлнө.

### УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна.

### ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДЛЫН ТӨЛБӨР



Даатгуулагч ҮОМШӨ улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно.

- Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопедийн (гурван жилд 1 удаа)
- Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний
- Сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны (жилд 1 удаа)

## УЛС, ОРНУУДЫН ТЭТГЭВРИЙН НАС

№	Орон	Эрэгтэй	Эмэгтэй
1	Ecuador	70	70
2	Iceland	67	67
3	Italy	66.7	62.7
4	Barbados	66.6	66.6
5	Portugal	66	66
6	Ireland	66	66
7	United States	66	66
8	Netherlands	65.6	65.6
9	Argentina	65	60
10	Costa Rica	65	65
11	Bahamas	65	65
12	Brazil	65	60
13	British Virgin Islands	65	65
14	Chile	65	60
15	Cuba	65	60
16	Honduras	65	60
17	Jamaica	65	64.9
18	Canada	65	65
19	Peru	65	65
20	Saint Lucia	65	65
21	Hong Kong	65	65
22	Japan	65	65
23	Taiwan, China	65	65
24	Micronesia, Federated States	65	65
25	Albania	65	60
26	Andorra	65	65
27	Austria	65	60

Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга

28	Malta	62-65	62-65
29	Latvia	62.9	62.9
30	Norway	62	62
31	Slovakia	62	62
<b>32</b>	<b>Монгол Улс (2025 онд)</b>	<b>62</b>	<b>57</b>
33	France	61.7	61.7
34	Korea Republic	61	61
35	Lebanon	60-64	60-64
36	Algeria	60	55
37	Egypt	60	60
38	Morocco	60	60
39	Sudan	60	60
40	Tunisia	60	60
41	Angola	60	60
42	Benin	60	60
43	Burundi	60	60
44	Coba verde	60	60
45	Cameroon	60	60
46	Ethiopia	60	60
47	Sierra Leone	60	60
48	Tanzania	60	60
49	Togo	60	60
50	Antigua and Barbuda	60	60
51	El Salvador	60	55
52	Guyana	60	60
53	Paraguay	60	60
54	Saint Vincent and the Grenadines	60	60
55	Uruguay	60	60
56	Venezuela, Bolivarian	60	55
57	Bahrain	60	55

## УЛС ОРНУУДЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Country	
1	Singapore	37.0
2	Italy	33.0
3	Uzbekistan	32.5
4	Brazil	29.5
5	Belarus	29.0
6	Moldova	29.0
7	Spain	28.3
8	Egypt	28.0
9	China	28.0
10	Czech Republic	28.0
11	France	27.8
12	Greece	26.5
13	Romania	26.2
14	Serbia	26.0
15	United Kingdom	25.8
16	Sudan	25.0
17	Tanzania	25.0
18	Azerbaijan	25.0
19	Tajikistan	25.0
20	Slovenia	24.4
21	Slovakia	24.4
22	Bosnia and Herzegovina	24.0
23	Isle of Man	23.8

Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга

24	Kyrgyzstan	23.3
25	Paraguay	23.0
26	Austria	22.9
27	Portugal	22.7
28	Argentina	22.4
29	Finland	22.4
30	Viet Nam	22.0
31	Russian Federation	22.0
32	Ukraine	22.0
33	Hungary	21.8
34	Albania	21.6
35	San Marino	21.5
36	Norway	21.2
37	Syrian Arab Republic	21.1
38	Iran, Islamic	21.0
39	Montenegro	20.5
40	Latvia	20.0
41	Nepal	20.0
42	Sri Lanka	20.0
43	Andorra	20.0
44	Croatia	20.0
45	Malta	20.0
46	Turkey	20.0
47	Estonia	20.0
48	Poland	19.5
49	Germany	18.6
50	Japan	18.3
51	Ethiopia	18.0

Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга

52	Saudi Arabia	18.0
53	Netherlands	18.0
54	Bulgaria	17.8
55	Sweden	17.8
56	Jordan	17.5
57	Oman	17.5
58	Liechtenstein	17.4
59	Algeria	17.3
<b>60</b>	<b>Монгол Улс</b>	<b>17.0</b>
61	Togo	16.5
62	Belgium	16.4
63	Luxembourg	16.0
64	Leuxembourg	16.0
65	India	15.7
66	Cyprus	15.6
67	Cuba	15.5
68	Sierra Leone	15.0
69	Uganda	15.0
70	Uruguay	15.0
71	Bahrain	15.0
72	Qatar	15.0
73	Yemen	15.0
74	Micronesia, Federated States	15.0
75	Guyana	14.7
76	Guernsey	14.5
77	Libya	14.3
78	Colombia	14.1
79	Venezuela, Bolivarian	14.0

## ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЦАХИМ СУВГУУД

- Нийгмийн даатгалын үйлчилгээний цахим систем  
<https://portal.ndaatgal.mn/>
- Төрийн үйлчилгээний цахим систем  
<https://e-mongolia.mn/>
- “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн



## ХОЛБОО БАРИХ УТАСНЫ ДУГААР

### Аймгийн нийгмийн даатгалын газар

Архангай	75079000
Баян-Өлгий	72022101
Баянхонгор	70444475
Булган	70342226
Говь-Алтай	70484217
Говьсүмбэр	70541289
Дархан-Уул	77057799
Дорноговь	70523223
Дорнод	70585955
Дундговь	70592309
Завхан	70463820
Орхон	75776699
Өвөрхангай	70322136
Өмнөговь	70533356
Сүхбаатар	70518351
Сэлэнгэ	70363463
Төв	70274004
Увс	70453425
Ховд	70431616
Хөвсгөл	75091000
Хэнтий	70562212

### Дүүргийн нийгмийн даатгалын газар

Багануур	70210021
Багахангай	70491151
Налайх	70232369
Баянзүрх	75558484
Баянгол	72001289
Сүхбаатар	70004300
Сонгинохайрхан	70175959
Хан-Уул	75103030
Чингэлтэй	70007790

### Нийгмийн даатгалын ерөнхий газар

Мэдээлэл, зөвлөгөө	7777-1289
	11-328030
Иргэдийн санал гомдол хүлээн авах	11-311131

